

Уулбаян сумын Засаг даргын Тамгын газрын
2022 оны 05 дугаар сарын үйл ажиллагааны тайлан

2022 оны 05 дугаар сарын 26-ны өдөр

Төрийн удирдлагын чиглэлээр:

Тавдугаар сард 119 албан бичиг бүртгэгдсэн байна. Үүнээс хариутай албан бичиг 21 ирсэн бөгөөд холбогдох албан тушаалтанд хүргүүлж, биелэлтийг ханган ажиллаж байна. Удирдлагын баримт бичгийн хувьд сумын Засаг даргын “А” захирамж – 101 батлагдсан бөгөөд хэрэгжилтийг тооцон ажиллаж байна. Нийт ирүүлсэн өргөдөл 13 (ажлын байр хүссэн-13) байна.

Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр:

Төрсний бүртгэл – 10 / эр -6/, Гэрлэсний бүртгэл -1, Нас барсны бүртгэл -4 /эр -4/

Иргэний үнэмлэх

Шинээр буюу 16 нас хүрсэн иргэн -10 (эр-4 эм-6), 25 буюу 45 насны сунгалт -25 (эр-10 эм-15)

Шилжин ирсний бүртгэл

Аймаг, хотоос шилжин ирсэн – 7, хүүхэд -3, Сум дүүрэгт шилжин ирсэн – 3, хүүхэд -1

Гэрчилгээ, лавлагаа олголт

Төрсний гэрчилгээ-2, Иргэнд лавлагаа – 32 олгосон.

Шинээр буюу 16 нас хүрсэн иргэн -10, 25 буюу 45 насны сунгалт -25

Шилжин ирсний бүртгэл

Аймаг, хотоос шилжин ирсэн – 7, хүүхэд -3, Сум дүүрэгт шилжин ирсэн – 3, хүүхэд -1

2022 оны 05 сарын 01-ээс “Тоон гарын үсгийн тухай хууль” хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан Тоон гарын үсгийн ач холбогдол, хэрхэн авах талаарх мэдээ мэдээллийг постер, бичлэг хэлбэрээр ЗДТГ-ын цахим хуудсаар мэдээллэв. Хууль хэрэгжиж эхэлснээс хойш 50 гаруй иргэнд тоон гарын үсэг олгосон. Мөн 16-аас дээш насны иргэдэд тоон гарын үсэг олгох мэдээ мэдээллийг олон нийтийн сүлжээгээр иргэдэд сурталчилж, анхан шатны мэдээлэлтэй болгосон.

Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчөө бүртгүүлээгүй 4 хуулийн этгээдэд 05 сарын 31-ний дотор бүртгүүлэх талаар зөвлөгөө өгч ажиллав.

Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулж буй 7-4-10 сургалтад 7 хоног бүр хамрагдан мэдлэгээ дээшлүүлсэн. Иргэдэд улсын бүртгэлтэй холбоотой мэдээ мэдээллийг түгээн ажилласнаар хугацаа хэтэрсэн бүртгэл байхгүй байна.

Төсөв санхүүгийн талаар

Монгол улсын 2022 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт орж орон нутгийн төсөвт үүссэн зарим нөхцөл шаардлага, хүлээгдэж буй гүйцэтгэл зэргийг үндэслэн 2022 оны 5-р сарын 16 нд аймгийн ИТХ-ын ээлжит 10-р хуралдаанаар аймгийн 2022 оны Төсвийг тодотгол хийж өөрчлөн баталсан. Дээрх өөрчлөлтийн хүрээнд аймгийн төсвөөс сумын төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийг /сургууль, цэцэрлэг, соёлын байгууллага/-ын үйлчилгээний ажилчдын цалингийн анхны батлагдсан төсвөөс эхний 4 сарын гүйцэтгэлийг 153,1 сая төгрөгийг хасаж батлах, орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг 29,7 сая төгрөгөөр хасагдаж баталхаар шийдвэр ирсэн. Үүний дагуу сумын ИТХ-ыг хуралдуулж төсвөө даруйхан батлуулах бэлтгэл ажлыг хийж байна.

ОНХС-ийн төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээ Үүнд

- Соёлын төвийн тайзны хөшиг хийх, гадна хашаа хийх тоног төхөөрөмж худалдан авах тендер 60,0 сая төгрөг /3 удаа зарлаж 1 ч компани оролцоогүй байна./
- Эрүүл мэндийн тоног төхөөрөмж худалдан авах тендер /Мед буян трейд ХХК/ 45,0 сая төгрөг
- Бага насны хүүхдийн тоглоомын талбай байгуулах тендер /Зотол констракшин ХХК/ 57,3 сая төгрөгөөр
- Ногоон байгууламжын хашаа хийх тендер зарлаад байна. /1ч компани оролцоогүй байна.

Шууд худалдан авалтын тендер

- Байгаль хамгаалах 20,0сая төгрөг/Ус-оюу ХХК худаг гаргасан/
- Зураг төсөв 3,5 сая
- Малын үүлдвэр угсааг сайжруулах ангилан ялгалт хийх 7,6 сая төгрөг
- Гамшигаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлыг хангах 9,5 сая төгрөг
- Бүтээн байгуулалтын засвар камержуулалт 6,2 сая төг

Санхүүгийн программ шинэчлэгдэж ЗДТГ Сити-с программыг ашиглан гүйлгээг хийж гүйцэтгэж байна. Соёлын төвийн байгууллага Динамик программ, ОНХС, СХСан Akylioss программ ашиглаж байна. 5-р сарын цалинг бүх албан байгууллага цахим системээр /тоон гарын үсэг/ хийгдлээ.

2017 онд малжуулалтаар олгосон 9 өрх, 2019 онд малжуулалтаар олгосон 10 өрхөөс малжуулалтын тооцоог хийж ЗДТГ-ын нэмэлтийн дансанд 5 өрх төлбөр тооцоогоо хийгээд байна.

Сүхбаатар аймгийн 80 жилийн ойд зориулсан бүх сумдын урлагын наадамд засаг даргын мөрийн хөтөлбөрөөс 3,8 сая төгрөгийг шийдвэрлэж урлагын наадамын үйл ажиллагааг амжилттай зохион байгууллаа.

Газар зохион байгуулалтын чиглэлээр:

1. Газар эзэмших эрхийн гэрчилгээг барьцаанд бүртгүүлэх, чөлөөлөх – 1 өргөдөл

2. Худалдах, худалдан авах гэрээний үндсэн дээр газар өмчилж авах – 2 өргөдөл,
3. Шинээр газар эзэмших – 1 өргөдөл,
4. Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар нэг удаа үнэгүй газар өмчилж авах – 5 өргөдөл

нийт 9 өргөдлийг газрын цахим системд бүртгэж холбогдох шийдвэрүүдийг гаргасан байна.

Байгаль орчны чиглэлээр:

Ногоон байгууламжийн чиглэлээр:

Сумын өнгө үзэмжийг сайжруулах, цөлжилтийг багасгах “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг орон нутаг хэрэгжүүлэх зорилгоор Бүх нийтээр мод тарих өдөрлөгийг зохион байгуулж байгууллаа. Сүхбаатар аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газраас тохижуулалтын зорилгоор өгсөн 2000 ширхэг хайлс модыг хүлээн авч тарилаа. Тус модны тариалалтад Засаг даргын Тамгын газар, Сургууль, Цагдаагийн ерөнхий газар, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Эмнэлэг гэх төрийн байгууллагуудтай хамтран Мод тарих ажлыг нэгдсэн удирдлаганд дор зохион байгуулж нийт оролцогчдод тэгш хувиарлан тариж гүйцэтгэсэн. Модыг эмнэлэгийн хойд талд болон сургуулийн хашаанд “П” хэлбэрээр нүхийг бэлдэж тариалсан. Мөн иргэд болон ААН байгууллагуудаас модны санал авч дахин мод тарих хөдөлгөөнийг зохион байгуулахаар төлөвлөөд байна.

Сумын төвийн ногоон байгууламжийг хариулагагүй мал амьтдаас хамгаалах, бүрэн бүтэн байдлыг шалгаж эвдэрч нурсан газруудыг засаж янзлан гагнуурын ажлыг нутгийн иргэнтэй хамтран 20 метр хашааг гагнаж заслаа. Тус ажлын зардалд байгаль хамгаалах сангаас шатахууны 15литр зарцуулагдсан.

Уул уурхайн чиглэлээр:

Иргэдийн төлөөлөгчдийн ээлжит хуралдаанаар “Сүнжүүрийн тойром” гэх газар нутгийг тусгай хамгаалалтад авах тухай 2022 оны 3 дугаар сарын 28 ны өдрийн 01\20 тоот тогтоолыг илгээж Геологи, уул уурхайн кадастрын бүртгэлд бүртгүүлсэн

Хөдөө аж ахуйн чиглэлээр:

2022 оны 03 дугаар сарын 11-ны өдөр Баруун-урт суманд зохион байгуулагдсан Сүхбаатар аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн салбарын мэргэжилтний зөвлөгөөнд амжилттай оролцсон

Орон нутгийн жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч нарын бизнесийн удирдлагын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, тэднийг уул уурхайн бэлтгэн нийлүүлэгч болох боломжийг нэмэгдүүлэх зорилго бүхий “Модуль-III” сургалт 2022 оны 05 дугаар сарын 17-оос, 19-ны өдрүүдэд зохион байгуулагдсан. “Модуль-III” сургалтад сумын хувиараа бизнес эрхлэгч 3 иргэн болон өөрийн биеээр оролцсон.

Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбооноос “Аймгийн ус, ой, газрын менежментийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй малчдын оролцоотой байгууллагыг бэхжүүлэх, хамтын менежментийн гэрээг боловсронгуй болгох” зөвлөх үйлчилгээний эхлэлийн уулзалт-семинарт 2022 оны 05 дугаар сарын 19-20-ны өдрүүдэд хамрагдсан.

Сүхбаатар аймгийн газрын харилцаа барилга хот байгуулалтын салбарын зөвлөгөөнд 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдөр амжилттай оролцсон. Уг сургалтад сумдын удирдлага, багийн засаг дарга нар, газрын даамлууд, ХАА мэргэжилтнүүд хамрагдсан улсын хэмжээний зөвлөгөөн болсон.

Мал эмнэлгийн чиглэлээр:

2022 оны 04 сарын 28, 29-ний өдрүүдэд аймгийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагч Р.Сайнбаяр, Онцгой байдлын газрын байцаагч Батсүх, аймгийн Мал эмнэлгийн газрын лабораторийн их эмч Д.Туяа нар шүлхий өвчний вакцины тарилгын ажлын хяналтаар ажиллаа.

Уг шалгалтаар тус сумын 15 өрхөөр орж тарилгын ажлын явц байдалтай танилцаж, үзлэг шалгалт хийхэд нэг малчны өрхийн эрүүл мэндийн дэвтэр нь шинэчлэгдээгүй хуучин дэвтэрт бичилт хийсэн байсан нь тогтоодсон. Өөр ямар нэгэн алдаа зөрчил илрээгүй тарилга хэвийн хийгдэж байна гэж үзсэн.

2022-04-18-ны өдөр Орон даяар хэрэгжүүлж буй дархлаажуулалтын аяны хүрээнд зохион байгуулагдсан гоц халдварт шүлхий өвчний вакцин, тарилга хийхэд шаардагдах эм тариур, ариутгалын бодис, ХХ-ын хувцас зэргийг аймгийн Мал эмнэлгийн газраас татан авч, 2022 оны 04 сарын 18 нд сумын Засаг даргын А/38 дугаар захирамж гаргуулан тарилгын ажлыг үндсэн 4 группээр зохион байгуулсан тарилганд 342 хот айлын 18050 үхэр хамрагдсан бөгөөд тарилгын ажлын гүйцэтгэл шаардагдах материалыг бүрдүүлж, нэгтгэн дүгнээд аймгийн Мал эмнэлгийн газарт хугацаанд нь хүргүүлсэн.

Аймгийн мал эмнэлгийн газраас 2022-04-18-ны өдөр шөвөг яр, сахуу, галзуугийн вакцинаас гадна үхрийн арьс товруутах өвчний 6,6 м/т вакцин, шингэлэгч 6,6 литрийг татан авсан.

2022 оны 05 сарын 11-ний өдөр сумын Засаг даргын А/50 дугаар захирамж гарган дархлаажуулалтын ажлыг 4 группээр зохион байгуулж байна.

Үхрийн арьс товруутах өвчин нь монголд анх удаа оношлогдсон, ОХУ-аас вакцин шинээр татан авсан зэрэг шалтгаанаар үхрийн арьс товруутах өвчний вакцины стандарт ажиллагааны зааварчилгаагаар малын эмч нарт сургалт зохион байгуулж, заавар арга зүйг баримтлан чанартай зохион байгуулах чиглэл өгсөн.

Өнөөдрийн байдлаар тарилганд 240 өрхийн үхэр-8784, тугал-2532 нийт-11316 хамрагдаад байгаа бөгөөд тарилгын явц 54,3%-тай байна.

Тайлангийн хугацаанд аймгийн Мал эмнэлгийн газраас 3 хариутай бичиг ирсэнийг барагдуулж, Улсын МЭЕГ-ын цахим хуралд 1 удаа аймгийн онцгой

комиссын цахим хуралд 1 удаа тус тус сууж шаардлагатай мэдээллийг авч ажилласан.

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, Боловсрол, Соёл, Эрүүл мэндийн чиглэлээр:

Нийгмийн халамжийн чиглэлээр:

Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр: нийт 11 төсөл авч, Одоогоор 3 төсөл хөтөлбөр нь дэмжигдэж ирсэн. ХАБЭА-н 2 хоногийн сургалтад хамрагдсан. ХБХүүхдийн комисс ирж 3 хүүхдийн асаргааны хугацаа сунгасан. АДЗөвлөлөөр 5 малжуулах төсөл хэлэлцэж шийдвэрлэсэн.

Халамжийн чиглэлээр:

Шинээр хүүхэд-5, цалинтай эх-2, асаргаа-5, цалинтай аав- 1 иргэн тус тус бүртгүүлсэн. Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх Оролцоо төсөлд төрийн үйлчилгээний нэгдсэн цахим систем E-mongolia хариуцсан ажилтантай хамтран 6 иргэнийг бүртгүүлсэн. Залуучуудын Старт-ап төсөлд 1 иргэний материал явуулсан.

Нийгмийн бодлогын чиглэлээр:

2022 оны 5-р сарын 1-нд Орлой түмэн эх уяачдын холбооны нээлтэнд зориулсан Их нас, Соёолон морьдын уралдаан, 5-р сарын 15-нд Баянмөнх уулын тахилгад зориулсан Азарга, Их нас, Соёолон морьдын уралдааны үед хүүхдийн аюулгүй байдлыг хангах үүднээс морьд гарахад хүүхдийн хамгаалалтын хувцас, хүүхдийн даатгалд хяналт тавьж ажилласан.

Хүүхдийн мөнгөө авч чадахгүй байгаа хүүхдийн нэрсийг гарган материал бүрдүүлж 1 хүүхдийн материалыг аймгийн ГБХЗХГ-т хүргүүлсэн.

Хамтарсан баг 1 удаа хуралдаж хүүхдийн биед гэмтэл учирсан асуудлаар хуралдаж аюулгүй зэргийн үнэлгээ хийж гэр бүлийн гишүүдэд хүүхдийн аюулгүй байдлын талаар яриа таниулга хийж ажилласан.

Аймгийн Нийгмийн бодлогын хэлтэст аймгийн Засаг даргын А/363 тоот албан бичгийн дагуу Сургууль, цэцэрлэг, хүүхдийн тоглоомын талбай, зам зэрэг газруудад хүүхдэд учирч болох эрсдлийн талаар хяналт хийж тайлан мэдээг хугацаанд хүргүүлсэн.

Нийгмийн даатгалын чиглэлээр:

Нийгмийн даатгалын шимтгэлд нийт 262553,1 мян төгрөгийн шимтгэл төвлөрүүллээ.

Үүнээс:

- Ажил олгогчоос шимтгэлд -204851,7 мян төг
- Сайн дурын даатгалын шимтгэл- 38808,2 мян төг
- ЭМДаатгалын шимтгэлд- 14235,2 мян төг орлоо.

Хэлтсээс 729000,0 мян төгрөгийн санхүүжилт авч 464 тэтгэвэр авагчдад 1095513,6 мян төгрөгийн тэтгэвэрийг олголоо.

СДДаатгалд 190 даатгуулагчидтай шинээр гэрээ байгуулан 38808,2 мян төгрөгийн шимтгэл , Эрүүл мэндийн даатгалд 168 даатгуулагчийг даатгаж 14352,2 мян төгрөгийн шимтгэл төвлөрүүлсэн.

Шинээр өндөр насны тэтгэвэр -16, тахир дутуугийн тэтгэвэр-0, тэжээгчээ алдсаны тэтгэвэр -0 нийт 16 тэтгэврийг тогтоож, 4 тэтгэвэр авагчийн тэтгэврийг өөрчлөн тогтоон олгоод байна.

Улсын төсвөөс 0 сая төгрөгийг тэтгэмжийн санхүүжилт оршуулгын тэтгэмж 3 тэтгэвэр авагчдад 3000.0 мян төгрөг, жирэмсэн амаржсаны тэтгэмжинд 3 даатгуулагчдад 6892.5 мян, Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж 8 даатгуулагчдад 693,9 мян төгрөгийн тэтгэмжийг тус тус олголоо.

2021 оны харилцахын-4, тооцооны хуудас тайлан-2, хөнгөлөлт чөлөөлөлтийн тайлан-1, малчны зөвлөлийн тогтоол баримтууд -1 зогсоогдсон 27 тэтгэврийн хувийн хэргийг архивлан нийгмийн даатгалын хэлтэст хүлээлгэн өгөв.

Тус хугацаанд тэтгэвэр тогтоолгох өргөдөл-16 ,т Банк солих-9 , тэтгэмж-14, ажилгүйдлын тэтгэмж-0 ,малчин малчнаар ажилласан жил тогтоолгох- 2 нийт 41 өргөдлийг хүлээн авч бүрэн барагдуулж , 586 иргэнд нийгмийн даатгалын үйлчилгээг хүргээд байна.

Нийгмийн даатгалын хэлтсээс 1 сарын 9-12 өдрүүдэд зохион байгуулсан сургалтанд амжилттай оролцож, 2021 оны тайланг нийгмийн даатгалын хэлтэст хүлээлгэн өглөө. Тэтгэвэр авагчийн 460 тэтгэврийн хувийн хэргийг тоолж бүртгэлийг шинэчилсэн.

Нийгмийн даатгалын сангийн орлогыг төлөвлөгөөг биелүүлэх, малчдыг сайн дурын даатгал болон Эрүүл мэндийн даатгалд бүрэн хамруулах зорилгоор багийн засаг дарга нарт сайн дур, эрүүл мэндийн төлөвлөгөөг хуваарилан Тамгын газрын даргаар батлуулан хамтарч ажиллаж байна.

Нийгмийн даатгалын байгууллагын үүсэж хөгжсөний 80 жилийн ой, " Даатгуулагчийн өдөр"-ийг тэмдэглэн өнгөрүүллээ. Тус арга хэмжээний үеэр шилдэг даатгуулагч тодруулах, сумын нийгмийн даатгалын товч танилцуулган бэлтгэн иргэд даатгуулагчдад сурталчлах , даатгуулагч, ажил олгогчийн дунд гар бөмбөгийн тэмцээн, цэнгүүн зэргийг зохион байгуулав

Шилдэг даатгуулагч гэр бүлээр Дэлгэр багийн малчин М.Алтансүлд, Шилдэг даатгуулагчаар Баян багийн малчин Л.Ганцоож тус тус шалгарлаа.

Гар бөмбөгийн тэмцээнд 9 баг тамирчид оролцон 3 байр эзлүүлэн шилжин явах цом, медаль, мөнгөн шагнал гардууллаа.

Ерөнхий боловсролын сургууль :

- Боловсрол Шинжлэх Ухааны Яам, НҮБ-ын хүүхдийг ивээх сан, Монголын улаан загалмайн нийгэмлэгээс Уулбаян ЕБС-д "Гэр бүлийн цаг" бичил төслийн 1 сарын хугацаанд 8 төрлийн ажил хийж гүйцэтгэнэ.
- 2022.04.30 - 2022.05.1 хооронд Хэнтий аймгийн Өмнөдэлгэр суманд болсон "Ялалтын гараа" цэцэрлэгийн аварга шалгаруулах 100 буудалт даам, шатрын тэмцээнд Хэнтий аймгийн 18 сум, төвийн 10 цэцэрлэг оролцсноос 6 насны ангилалд "Оюунлаг" клубын тамирчин М. Ивээл шатрын төрөлд "Мөнгөн медаль", 100 буудалт даамны төрөлд Д.Ариунсолонго "Алтан медаль" хүртэж амжилттай оролцлоо. Бэлтгэсэн багш Э.Мөнхбаатар
- 1 дүгээр ангийн нийт 60 сурагч "Уншиж, бичиж, бодож сурлаа" тайлант өдөрлөгийг зохион байгуулав.
- "Сайн багшийн-Сайн технологи" аймгийн багш нарын ур чадварын уралдааны нийгмийн ухааны багш нарын төрөлд МХУЗ-ын багш П.Урантуяа ТЭРГҮҮН байр эзлэв.
- 5 дугаар сарын 10-ны өдөр "Хайр түгээе-Хамтдаа хөгжье" эцэг эхийн зөвлөгөөнөөр өртөөчилсөн сургалтыг зохион байгууллаа. Үүнд:
 - 1-р өртөө: 6-10 насны хүүхдийн зан төлөвийн онцлог - Сургалтын менежер Д.Уугансүрэн, бага ангийн багш Ж.Мөнх-Од
 - 2-р өртөө: Хүүхэд хүмүүжлийн эерэг арга, кейс дээр ажиллах - Нийгмийн ажилтан Т.Вера, Бага ангийн багш Ж.Мөнхсайхан
 - 3-р өртөө: Эцэг эхийн модуль - Бага ангийн багш Э.Шинэтуяа, Э.Түмэнжаргал
 - 4-р өртөө: " Математикаараа хөгжиж, массаараа манлайлья " төслийн танилцуулга - Бага ангийн багш Г.Тунгалаг, Д.Мөнхгэрэл
 - 5-р өртөө: AR технологийг сургалтад ашиглаж байгаа давуу талууд -Физикийн багш О.Сарангэрэл
- Сургуулийн захирал З.Эрдэнэчимэг "Сургуулийн хэтийн зорилго, үйл ажиллагаа"-ны талаар нэгдсэн мэдээллийг өгч, сэтгэл санамжийн судалгаа авлаа.
- "Жаахан шаргын нутаг" монгол бичгийн уралдааны "Цахим контент"-ын төрөлд монгол хэл уран зохиолын багш Л.Мөнхтуяа ТЭРГҮҮН байр эзэлж, үндэсний бичгээ түгээн дэлгэрүүлэх их үйлсэд нь амжилт гаргалаа.
- "Гэр бүлийн цаг" бичил төслийн хүрээнд төслийг хэрэгжүүлэх багаас "Гэр - сургууль - Гэр" маршрутыг мөрдөх, өвчлөлийн талаарх мэдээлэл бүхий гарын авлагыг боловсруулан 1-9-р ангийн 450 сурагчдад тарааж, мэдээллийг танилцууллаа. 2022.05.12
- Сумын нийтийн номын санч П.Ганцэцэг, НТБ –ын нэгжийн багш О.Ариунцэцэг, бага ангийн багш Ж.Мөнх-Од нар хамтран 16 ангийн эцэг эхчүүддээ угийн бичгийн сургалт авлаа. Нийт 14 эцэг эх хамрагдав.
- "Гэр бүлийн цаг" төслийн хүрээнд 11 багш "Шүдээ зөв арчлах", "Амны хөндийн эрүүл ахуйд мөрдөх 8 зөвлөмж", "Амны хөндийн эрүүл ахуйд мөрдөх 8 зөвлөмж" зэрэг сэдвээр зөвлөмж шторк бэлтгэн нээлттэй группэд байршуулав.
- Баруун -Урт суманд 2022 оны 5-сарын 14 зохиогдсон нээлттэй тэмцээний "100 буудалт даам"-ны насанд хүрэгчдийн ангилалд Х.Чаминчулуун "Алтан медаль" хүртсэн байна.

- Сүхбаатар аймагт 5 сарын 14-15 нд зохион байгуулагдсан интерактив хичээл бэлтгэх аргазүй сургалтад бага ангийн 4 багш амжилттай хамрагдлаа. Сургалтаар багш нар маань дараах зүйлд суралцлаа.
 1. Excel программын өргөн хэрэглээний томьёо функцыг ашиглах
 2. PowerPoint программыг ашиглан цахим хичээл бэлтгэх
 3. Интерактив хичээл бэлтгэх аргазүй
- Боловсрол Шинжлэх Ухааны Яам, НҮБ-ын хүүхдийг ивээх сан, Монголын улаан загалмайн нийгэмлэгээс Уулбаян ЕБС-д хэрэгжиж буй **"Гэр бүлийн цаг"** төслийн хүрээнд **"Хөдөлгөөн-эрүүл мэнд"** алхалт, дасгалын цахим уралдааныг удирдамж боловсруулан 5 дугаар сарын 16-27 өдрүүдэд зохион байгуулав.
- ба ангийн сурагч "Аймгийн угсаатны зүйн музей"-г үзэж сонирхон, түүх, өв соёлтойгоо танилцлаа. Мөн ерөнхий сайд Ц.Жигжиджавын хөшөө, Егүзэр хутагтын хөшөө, Ардчилсан хувьсгалын 20 жилийн ойд зориулсан хөшөө, жанжин Д.Сүхбаатарын талбай, хөшөө, "Соёмбо цогцолбор" зэрэг түүхэн дурсгалт газруудаар аялав.
- АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг, НҮБ-ийн Хүүхдийн сангийн санхүүжилтээр "Гэр бүлийн цаг" бичил төслийн хүрээнд үйлчилгээний 9 ажилчинд "Ариутгал халдваргүйжүүлэлтийг хэрхэн хийх, ариутгалын бодисыг хэрэглэх заавар"-ын сургалтыг зохион байгуулж, дадлага ажил хийлээ. 2022.05.17
- Олон улсын музейн өдрөөр зохион байгуулагдсан "Музей ба дурсамж" эсээ бичлэгийн уралдаанд МХУЗ-ын багш Л.Мөнхтуяа "Тэргүүн" байр эзэлсэн.
- 2022-05-17-ны өдөр БШУЯ, НҮБ-ын Хүүхдийг ивээх сан, Монголын улаан загалмайн нийгэмлэгийн санхүүжилтээр хийгдэж буй **"Гэр бүлийн цаг"** төслийн хүрээнд зохион байгуулсан **"Би эцэг эхийнхээ гар утас нь болмоор байна"** чин сэтгэлийн ярилцлагыг 1-9-р ангийн сурагчид, эцэг эхчүүдийн дунд зохион байгуулахад эцэг эх, хүүхдүүд санал бодлоо чөлөөтэй солилцлоо. Энэхүү ярилцлагын үеэр эцэг эх сурагчдаас гарсан саналыг нэгтгэн дүгнэвэл:
 1. Эцэг эхчүүд бид хүүхдийнхээ дэргэд гар утасныхаа хэрэглээг хязгаарлацгаая.
 2. Хүүхдэдээ ухаалаг утсыг хэрэглэх цагийн хязгаарыг заавал тогтоож өгье.
 3. Гэртээ номын сантай болж сар бүр ном худалдан авч хүүхэдтэйгээ хамтдаа ном уншицгаая.
 4. Эцэг эх бүр хүүхдийнхээ цахим орчны хэрэглээнд хяналт тавьж, хичээл сурлага, хүмүүжил төлөвшил, эрүүл мэндэд нь анхаарал хандуулцгаая.
 5. Хүүхдэдээ цаг гаргаж сонсож, ойлгож, ярилцаж, өглөө бүр тэвэрч, үдэш бүр сайн сайхан үгийг хэлж хэвшицгээе.
 6. Эцэг эхчүүд бид хүүхдээ монгол ахуй амьдрал, уламжлалт зан үйлд нь ойртуулж, ахуй амьдралын дадал хэвшилд сургацгаая.
- 5 дугаар сарын 19 нд "Гэр бүлийн цаг" төслийн хүрээнд Ж.Мөнх-Од багштай 1б анги эцэг эхчүүдийнхээ дунд гар бөмбөг, 100 буудалт даам, дартсны тэмцээн зохион байгууллаа. Тэмцээнүүдийг эцэг эхийн төлөөлөл Б.Дугармаа, Б.Жанцанхорол, М.Урангоо, М.Өлзийбаяр, Туяа нар ивээн тэтгэв.

- Орос хэл эхлэн суралцаж буй 7а,7б ангийн сурагчдын дунд хичээлийн жилийн турш үзсэн агуулгаар "BOB" тэмцээн зохион байгуулсны үр дүнд сурагчид үгийн баялгаа нэмэгдүүлж ярих чадвараа сайжрууллаа. Тэмцээнд нийт 32 сурагчид оролцлоо.
- “Smart education” төслийн уралдаанд 22 сурагч материал явуулснаас 6 сурагч шалгарч ухаалаг утастай болсон байна.
- 1. П.Урантуяа багштай 6а ангиас 2 сурагч материал явуулснаас Д.Пүрэвбат
- 2. Ц.Алтантүлхүүр багштай 6б ангиас 2 сурагч материал явуулснаас Г.Сугаррагчаа
- 3. А.Сайханцэцэг багштай 7а ангиас 5 сурагч материал явуулснаас Н.Өсөхбаяр
- 4. Д.Сарантуяа багштай 8а ангиас 3 сурагч материал явуулснаас Ш.Түвшинбаяр
- 5. Н.Уранбилэг багштай 8б ангиас 3 сурагч материал явуулснаас Н.Биндэр
- 6. Л.Мөнхтуяа багштай 9а ангиас 5 сурагч материал явуулснаас М. Мөнхзаяа нар тус тус шалгарлаа.

Хүүхдийн цэцэрлэг:

- Байгууллагын эрхлэгч БШУЯ-наас зохион байгуулж буй эрхлэгч, аргазүйчдийг чадавхжуулах сургалтад хамрагдаж байна.
- “Үр дүнгийн баяр”-ыг зохион байгуулж 4 бүлгийн 127 хүүхдийг хамруулан 170 гаруй эцэг эхчүүдэд сонирхууллаа.
- “Үр дүнгийн баяр”-ын үеэр
 - Урлагийн тоглолт
 - Багш, хүүхдүүдийн бүтээлийн үзэсгэлэн
 - 5 настнуудад Батламж гардуулах үйл ажиллагаа
 - Азын сугалаа зэргийг зохион байгууллаа.
- Хүүхэд бүрийн үнэлгээг хийж, үнэллээ.
- Илүүдэл жингүй-Эртэч монгол аяны хүрээнд сумын албан байгууллагуудын албан хаагчдын дунд 18,20-ны өдрүүдэд өглөөний дасгал гүйлтийг зохион байгуулж халуун чацаргана, витамин өглөө.
- “Халдвараас сэргийлэхэд хариуцлагатай аавуудын оролцоо” сэдэвт бичил төслийг бичин МУЗНН-ийн төслийн шалгаруулалтад шалгарлаа.
 - Төслийн хүрээнд “Амны хаалтны ач холбогдол” бүтээлийн уралдаан
 - 3 удаагийн сургалт хэлэлцүүлэг зохион байгуулж давхардсан тоогоор 57 хүүхэд 115 эцэг эхийг хамрууллаа.
- “Урлагийн наадам”-д манай байгууллагаас 4 багш, ажилтан оролцсон.
- Тус наадамд оролцогчдын 1 өдрийн хоолыг даан хийж өглөө.
- 6.1нд хүүхэд баярлуулах зорилгоор хандивын аяныг зарлаад байна.

Эрүүл мэндийн төв:

1. Эмнэлгийн тусламж үйлчилгээ
 1. Бүгд үзлэг -1549
 2. Амбулаторийн үзлэг -1012

3. Урьдчилан сэргийлэх үзлэг-385
4. Идэвхитэй хяналт-26
5. Гэрийн эргэлт-11
6. Алсын дуудлага-35
7. Гэрийн дуудлага - 107
8. Хэвтэн эмчлүүлсэн – 24 үүнээс хүүхэд -12
2. Эрт илрүүлэгийн үзлэгт
 - Артерийн гипертензи -120
 - Чихрийн шижингийн – 120
 - Хөхний эрт илрүүлэг -140
 - Умайн хүзүүний эсийн шинжилгээ-40
3. Ковид -19 нэмэлт тунгийн вакцинжуулалт 3,4 тунгийн вакцинжуулалт энэ сард хийгдээгүй байна.
4. Товлолт вакцинжуулалт 0-2насны 39 хүүхдийг товлот дархлаажуулалтанд хугацаанд нь хамруулсан.
5. 6-59 сартай 140 хүүхдийг А аминдэмийн өндөр тунт витамин уулгасан.
6. 0-5 насны 169 хүүхдийг жигнэсэн.
7. ЭМС-ийн А/139 дүгээр тоот тушаалын дагуу эрт илрүүлэгийн үзлэгийн нээлтийг улс орон даяар нэгэн зэрэг 05-дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулах шийдвэрийн дагуу, эрүүл мэндийн төв дээр эрт илрүүлэгийн үзлэгийн нээлтийг хийж иргэд хөдөлмөрчидөд мэдээллийг өгсөн.
8. ЭМТ-ийн фурган машин нь 11 сараас хойш эвдрэлтэй байсан тул 11 сая төгрөгөөр ээлжийн мотор тавиулсан.
9. ЭМЯ-аас фурган машиныг 05 дугаарын сарын 20 ны өдөр өгсөн.
- 10.Тэр бум мод хөтөлбөрийн хүрээнд байгууллагын хашаанд 200 ш хайлаас модыг тарьсан.
- 11.УБ хотод ШУГТЭ сувилагч Э.Мянганзул “Сувилахуйн тусламж үйлчилгээний аюулгүй байдал” сэдэвт 2 өдрийн сургалтанд, Аймгийн эрүүл мэндийн газарт “Эрт илрүүлэгийн үзлэг” сургалтанд их эмч У.Пунцаг, бага эмч Г.Алтантуяа нар 3 өдрийн сургалтанд хамрагдсан.ЭМГ, ЭМЯ, Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгээ сзохиогдсон цахим сургалт 5 удаагийн сургалтанд давхардсан тоогоор 15 эмч мэргэжилтэнгүүд хамрагдаад байна.
- 12.ЭМЯ, ЭМГ, Сумын ЗДТГ-аас нийт 13 төрлийн албан бичиг ирсэн байна.

“Хууль, эрх зүйн чиглэлээр:

Хагас жилийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээний хийх тухай албан бичгийг төсөвт байгууллага, мэргэжилтэнгүүдэд 05 дугаар хүргүүлж, 06 дугаар сарын эхээр зохион байгуулахаар төлөвлөсөн.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим системд Сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Сумын 2022 оны хөгжлийн төлөвлөгөө, аймгийн Засаг даргаас сумын Засаг даргатай байгуулсан гэрээ гэсэн 3 бодлогын баримт бичгийг оруулсан.

Төсөвт байгууллагын дарга, эрхлэгч, дотоод ажилтан, ЗДТГ-ын мэргэжилтэнгүүдэд хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим систем, үйл ажиллагааг хэрхэн тайлагнах, нотлох баримт цуглуулах зэрэг мэдээллийг хүргэж, мэргэжилт, арга зүйн туслалцаа өгч ажиллалаа.

Эрх зүйн хөтөчөөр суралцах албан хаагчдын мэдээллийг холбогдох дээд шатны байгууллагад хугацаанд нь хүргүүллээ.

Албан хаагчдын хувийн хэрэг хөтлөлтийг бүрэн бүрдүүлж, хүний нөөцийн ажилтнаар хувь хүний нууцыг хадгалах, баталгаа гаргууллаа.

Тоон гарын үсэг нэвтэрч эхэлсэнтэй холбогдуулан түүний ач холбогдлын талаар нийт ард иргэдэд мэдээлэл өгч, танилцуулга бичлэг хүргэсэн бөгөөд үр дүнд нь иргэдийн тоон гарын үсэг авах, түүгээр үйлчилгээ авах иргэдийн тоо нэмэгдэж байна. Төрийн үйлчилгээний оператороос энэ сард 20 лавлагаа, тодорхойлолтыг тоон гарын үсгээр түргэн шуурхай олгосон байна.

ERP цахим системийг албан хаагчид ашиглан, цагаа тогтмол бүртгүүлж байна. Бид цаасны хэрэглээг бууруулах үүднээс ирсэн бичгийг хэвлэхгүйгээр, цахим системээр хүлээн авч, танилцаж, үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Мягмар, Пүрэв гарагийн 07.30 цагийг Төрийн албан хаагчдын сургалтын өдөр болгон зарлаж, тогтмол мэдээлэл өгч, албан хаагчдын мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлж байна.

Байгууллагын даргын шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг бүрэн хангуулж тушаал-10, албан тоот-5, удирдамж-3 тус тус боловсрууллаа.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Архинаас татгалзах, тамхины хор уршгийн талаар олон нийтэд мэдээллийг бичлэг, постероор мэдээллээ.

2022 оны 03-05 дугаар сарын хооронд байгууллагын албан хаагчдын дунд зохион байгуулсан “Хандлагаа өөрчилж-Хамтдаа хөгжье” аяны хүрээнд шалгарсан албан хаагчдаа шагнаж, урамшуулаа.

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН: ХУУЛЬ,
ЭРХ ЗҮЙН МЭРГЭЖИЛТЭН

Л.ДАШБАЛЖИННЯМ